

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2020.01.20 - 01.24

Ти Ди Би Капитал ҮЦК нь Монголын хөрөнгийн биржтэй шууд холбогдсон арилжааны системийг ашиглан үнэт цаасны арилжаанд хамгийн түргэн шуурхай оролцох боломжийг олгож байна.

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Амралтын өдөр таарсан энэ долоо хоногт улирлын тайлангууд нийтлэгдэхтэй зэрэгцэн БНХАУ-д шинэ төрлийн коронавирус тархсантай холбоотой АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай байлаа.

Зах зээлийн үнэлгээ ихтэй индексүүд болон технологийн салбарын компаниудыг түлхүү агуулдаг Nasdaq индекс энэ долоо хоногт түүхэн дээд хэмжээндээ хүрсэн ч Баасан гарагт огцом уналт үзүүлээ.

Урт хугацаатай бондын өгөөж буурсан нь ус, цахилгаан болон дулааны салбарын компаниудын тараадаг, өндөр хэмжээний ногдол ашигт хөрөнгө оруулагчдыг татсанаар, ус, цахилгаан болон дулааны салбарын компаниудын хувьцаа хамгийн их өсөлттэй байлаа. Эрчим хүчний салбарын компаниудын хувьцаа газрын тосны үнэ 1-р сарын 6-аас хойш унаж байгаатай холбоотой бууралттай байлаа. Шинэ төрлийн коронавирустай холбоотой дэлхийн аялал жуулчлалын салбар уналтад орно гэсэн хүлээлт газрын тосны үнэд хамгийн их нөлөөлж байна.

Европ: Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд хөдөлгөөн багатай байлаа. ХБНГУ-ын эдийн засгийн сүүлийн үзүүлэлтүүд сайжирсан ч Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас БНХАУ-д шинэ төрлийн коронавирус тархсаныг зарлалаа.

Их Британи улсын үндэсний сангийн канцлер Сажид Жавид Financial Times-д (FT) өгсөн ярилцлагадаа Их Британи улс Европын холбооны бодлогод баригдахгүй ба энэ оны эцэс гэхэд нэгдсэн эдийн засаг болон гаалийн бодлогын холбооноос гарна гэдгээ мэдэгдлээ. Мөн тэрээр, засгийн газар Европын холбооны дүрмийн дагуу зохицуулалтуудыг хүсэж буй томоохон үйлдвэрлэгчдийг дэмжихгүй гэдгээ мэдэгдлээ. Энэхүү мэдэгдэл нь Их Британи улс Европын холбооноос гарахдаа баримтлах хэлэлцээрийн бодлогын өөрчлөлтийг харуулж байгаа юм.

Евро бүсийн хамгийн том эдийн засгууд болох ХБНГУ болон Франц улсын эдийн засгуудын 1-р сарын үйлдвэрлэлийн гарц сүүлийн 5 сарын хамгийн дээд төвшинд хүрсэн байна.

Япон: Энэ долоо хоногт Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай байлаа. Япон улсын экспортын хэмжээ 12-р сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүлээлтээс их буюу 6.3% буурсан байна. Энэхүү бууралт нь 2016 оноос хойших хамгийн их буурсан үзүүлэлт болсон юм. Хэдийгээр АНУ болон БНХАУ-ын хооронд худалдааны эхний шатны хэлэлцээр батлагдсан ч Япон улсын экспортын бууралт үргэлжлэх хандлагатай байгаа юм.

БНХАУ: 11 сая хүн амтай Вухан хотод шинэ төрлийн коронавирус тархсантай холбоотой БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоног их хэмжээний бууралттай байлаа.

2003 оны SARS-ийн тархалттай харьцуулахад адил төстэй зүйлс байгаа ч мөн томоохон ялгаанууд байгаа юм. Шинжээчдийн үзэж байгаагаар БНХАУ-ын өнөөгийн эдийн засаг хэрэглээ төвтэй байгаагаас үүдэн илүү эмзэг байгаа юм. Шинэ төрлийн коронавирусын тархалтаас үүдэн БНХАУ-ын эдийн засагт томоохон хохирол учир байгаатай холбоотой эдийн засгийн идэвхжүүлэх богино хугацааны арга хэмжээ авах магадлалтай байгаа юм.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	18,999.02	-0.53% ▼
Dow Jones	АНУ	28,989.73	-1.22% ▼
S&P 500	АНУ	3,295.47	-1.03% ▼
Nasdaq	АНУ	9,314.91	-0.79% ▼
S&P/TSX	Канад	17,565.34	0.04% ▲
FTSE 100	Их Британи	7,585.98	-1.15% ▼
S&P/ASX 200	Австрали	7,090.50	0.37% ▲
Nikkei 225	Япон	23,827.18	-0.89% ▼
Hang Seng	Хонг Конг	27,949.64	-3.23% ▼

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	114.72
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	103.66
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	102.55
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	108.77
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.12
DBM' 2023	USD	7.250%	107.45
TDBM' 2020	USD	9.375%	101.61
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	98.47

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	1.654	-0.02 ▼
Libor 3M	1.819	-0.02 ▼
Libor 6M	1.845	-0.03 ▼
Libor 1YR	1.923	-0.04 ▼
US 2YR Bond	1.559	-0.01 ▼
US 3YR Bond	1.567	-0.02 ▼
US 5YR Bond	1.620	-0.01 ▼
US 10YR Bond	1.822	0.00 ▲

Валютын ханш	2020.01.24	Өөрчлөлт
USD	2,749.37	0.11% ▲
CNY	396.35	-1.02% ▼
EUR	3,039.02	-0.63% ▼
RUB	44.50	-0.38% ▼
KRW	2.35	-0.84% ▼
JPY	25.10	0.72% ▲
CAD	2,093.80	-0.63% ▼

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,571.53	0.92% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	18.10	0.33% ▲
Зэс	USD/lb.	268.40	-5.68% ▼
Нүүрс	USD/MT	68.53	-3.04% ▼
WTI газрын тос	USD/bbl.	54.19	-7.43% ▼
Brent газрын тос	USD/bbl.	60.69	-6.41% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. XII	5.2%
Бодлогын хүү	2019. XII	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. XII	11.02%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. XII	11.29%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. XII	4.75%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. XII	16.84%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. XII	10.35%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg


МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 42 компанийн 2,864.3 сая төгрөгийн 4,444,650 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Монгол даатгал” /CHE/ компанийн хувьцаа 52.06%-аар буюу хамгийн ихээр өсөж 122.41 төгрөг хүрч хаагдсан бол “Ханын материал” /НМК/ компанийн хувьцаа 14.55%-аар буурч 1,880.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

01-р сарын 24-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,864.3 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 18,999.02 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.53%-аар буурсан байна.



Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)
Арилжигдсан үнийн дүн	2,864.3
Зах зээлийн үнэлгээ	2,673,677.7

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	18,999.02	-0.53% ▼
MSE I индекс	9,330.09	-0.28% ▼
MSE II индекс	7,850.39	0.68% ▲

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Монгол шуудан	3,116,782	1,956,055,223
Ард санхүүгийн нэгдэл	461,914	777,323,485
Мандал даатгал	288,670	14,453,567
Монос хүнс	170,831	11,979,005
Лэндмн ББСБ	78,096	3,430,887

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Монгол даатгал	122.41	52.06% ▲
УБ-БҮК	345.00	15.00% ▲
Авто импекс	2,300.00	14.71% ▲
Гермес центр	146.00	8.96% ▲
Шивээ овоо	2,555.00	6.46% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Ханын материал	1,880.00	-14.55% ▼
Мерекс	20.00	-9.17% ▼
Хөх ган	80.00	-9.09% ▼
Ариг гал	2,807.00	-6.40% ▼
Стандарт проперти групп	66.00	-5.71% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
Ард Секюритиз	5,468,056,051
Голомт Капитал	41,441,820
Би Ди Сек	38,032,196
Ти Ди Би Капитал	36,322,152
Бумбат-Алтай	25,270,967

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	ЗЗҮ (сая.төг)
АПУ	635.18	675,947
Таван толгой	6,500.00	342,324
МИК Холдинг	15,000.00	310,640
Говь	270.00	210,630
Инвекор ББСБ	2,198.00	157,658

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ



- Шунхлай групп: "АПУ" ХК дахь "Монголиан бэвэриж инвестментс" компанийн хувьцаа худалдан авах хэлцэлийг хийсэн байна.
- Д.Сумьяабазар: "ЭТТ"-н ногдол ашиг тараахыг ирэх сарын 15-аас өмнө шийднэ.
- СЗХ-ноос зохион байгуулсан "Компанийн бондын зах зээлийн хөгжил ба зохицуулалтын орчин" сэдэвт хэлэлцүүлгийн үеэр МҮЦАЭХ-ны Удирдах зөвлөлийн дарга Б.Өлзийбаяр зээлжих зэрэглэл тогтоох компани байгуулахаар төлөвлөж буйг мэдээллээ.

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

- "Мандал даатгал" ХК-аас Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 443 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам"-ын 3.2-д "Компаниас тухай бүр нийтэд хүргэх мэдээлэлд дараах мэдээлэл хамаарна" гэж заасны дагуу 3.2.2.11-д "Компани шүүхэд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох"-той холбоотой мэдээллийг хүргүүлсэн.
- 2020 оны 1-р сарын 21-ний өдөр "Ард санхүүгийн нэгдэл" ХК-ийн хувьцаа 746.1 сая төгрөгөөр арилжигдлаа.
- "Монгол шуудан" ХК-ийн 800,046 ширхэг хувьцаа 504.0 сая төгрөгөөр арилжигдан үнийн дүн болон тоо ширхэгээр идэвхитэй байв.
- "Харшийн гэрээ" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдөр болно.




ШИНЖЭЭЧИЙН БУЛАН

Сүүлийн үед "АПУ" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэцтэй холбоотой томоохон өөрчлөлтүүд ихээр гарах болсон билээ.

Тэгвэл хамгийн сүүлд 2020 оны 1-р сарын 20-нд "Шунхлай Групп" ХХК нь "Монголиан Бэвэриж Инвестментс" ХХК-ийн эзэмшиж байсан 55,212,572 ширхэг буюу нийт хувьцааны 5.19%-ийг авч байгаа бөгөөд энэхүү хэлцэл нь биржийн бус хэлцлээр явагдсан байна. Энэхүү хэлцлийн үр дүнд "Шунхлай Групп" ХХК нь АПУ ХК-ийн нийт хувьцааны 56.03% буюу 541,017,070 ширхэг хувьцааг эзэмшиж байгаа юм.

Үүнээс өмнө, өнгөрөгч оны 7-р сарын 31-нд "Шунхлай Групп" ХХК-ийн зүгээс "Вит Альянс Лимитэд" болон "Туул интернэшнл" ХХК-ийн хувьцааг биржийн бус хэлцлээр шилжүүлэн авч "АПУ" ХК-ийн 50.84%-ийг эзэмшээд байсан билээ.



ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

- Монгол эмийг Энэтхэгийн зах зээлд нэвтрүүлэхээр ажиллаж эхэлжээ.
- Дэлхийн эдийн засгийн чуулган эхэллээ.
- Нэг хүнд ногдох ДНБ 4,470 ам.долларт хүрчээ.
- Татварын орлого 1.5 их наядаар есжээ.
- Монголбанк "Ариг" банканд бүрэн эрхт төлөөлөгч томилов.
- Коронавируст халдвараас сэрэмжлүүлсэн зөвлөмжийг ЭМЯ гаргажээ.
- Монгол Улс, БНХАУ-ын хилийн авто замын боомтуудыг хаалаа



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

- Монголбанк "Ариг" банканд бүрэн эрхт төлөөлөгч томилохоор шийдвэрлэсэн байна. Тодруулбал, Банкны тухай хуулийн 49-р зүйлд зааснаар "Монголбанк хуульд заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь тухайн банкны үйл ажиллагааг сайжруулах, найдвартай тогтвортой удирдлагыг сэргээхэд хангалтгүй гэж үзсэн, эсхүл хуулийн 3.1.16-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд банканд нөхцөлт удирдлагыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, бүрэн эрхт төлөөлөгчийг томилж болно" гэсэн байдаг.
- Коронавируст халдвараас ард, иргэд хэрхэн сэргийлэх талаар зөвлөмжөөс сонордуулж байна. Тухайлбал, өвчлөл бүртгэгдсэн улсад зорчихгүй байх, амны хаалт тогтмол зүүж хэвших, гараа тогтмол савандаж угаах, бага насны хүүхдийг олон нийтийн газар дагуулж явахгүй байх, дархлаа сайжруулах амин дэм хэрэглэхийг Эрүүл мэндийн яам зөвлөж байна.



ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Дорнод аймгийн Цагаан овоо сумын нутагт орших Алтан цагаан овоо алтны үндсэн ордын төсөл хэрэгжүүлж буй "Steppe Gold" (TSE:STGO) компани "Ди Би Эм ассет менежмент ҮЦК" ХХК-иас 3 сая ам.долларын хөрөнгө татан төвлөрүүлэхээр болсон талаар мэдээллээ. Тодруулбал Хөгжлийн банкны охин компани болох "Ди Би Эм ассет менежмент ҮЦК"-ийн удирдлага дор ажилладаг "Монголын үндэсний хөрөнгө оруулалтын сан ХОС ТЗК"-аас уг хөрөнгийг татан төвлөрүүлж байна.



МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.